



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

Комисс байгуулах, зарим гишүүнийг  
чөлөөлөх тухай


Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл, Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Иргэний Зөвлөлийн дүрэм”ийн 3.4.6, Иргэний зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Иргэний зөвлөлийн зарим гишүүнийг сонгон шалгаруулах комиссыг хавсралтын ёсоор байгуулсугай.

2.Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, дүрэмд заасны дагуу зохион байгуулж 2016 оны 03 дугаар сарын 15-ны дотор дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхийг сонгон шалгаруулах комисст даалгасугай.

3.Иргэний зөвлөлийн гишүүнээр ажиллах хуулийн хугацаа нь дууссан Д.Мягмарсүрэнг, Биеийн эрүүл мэндийн шалтгааны улмаас цаашид ажиллах боломжгүй болсон Ц.Рагчаа нарыг Иргэний зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

ДАРГА



Б.МЯГМАРСҮРЭН

001 0422